



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/051/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор	Г.Нандинжаргал
	Утас: 7000-7734	Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер	Х.Түвшинбаяр
	Утас: 315558	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 315558	Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Н.Бадамхатан
	Утас: 325093	Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

байна. Мөн 2022-2024 онуудад арилжааны 4 банктай хамтран 4,904.6 сая төгрөгийн зээл бичил бизнес эрхлэгчдэд олгосон бөгөөд зээлийн 2,264.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, хэвийн төлөгдөж байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ын тайлант оны төсвийг Нийслэлийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 25/132 тогтоолоор 848.7 сая төгрөгөөр баталсан. Энэ нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс 16.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд тус байгууллага нь ЮНЕСКО-гийн “Бүтээлч хотуудын нэгдсэн сүлжээ” арга хэмжээний хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Толгойтод шинээр барилга ашиглалтад оруулж, Хүнс хөдөө аж ахуйн яам болон Дэлхийн банкны санхүүжилтээр 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилго, 13 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдаж, үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,422,071,692.63</u>	<u>15,449,491,413.52</u>
33	АВЛАГА	13,221,572,954.48	12,422,068,784.92
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	258,397.30
33300	Татаас, санхүүжилтийн авлага	136,968,969.31	136,968,969.31
33400	Зээлийн хүүгийн авлага	52,895,509.42	45,699,089.16
335	Бусад авлага	6,643,250,791.19	5,992,311,516.21
3351	Байгууллагаас авах авлага	6,632,458,785.19	5,963,776,629.41
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,792,006.00	28,534,886.80
336	Зээлийн авлага	6,388,457,684.56	6,246,830,812.94
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	6,388,457,684.56	6,246,830,812.94
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	6,388,457,684.56	6,246,830,812.94
35	БАРАА МАТЕРИАЛ	200,498,738.15	3,027,422,628.60
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	1,618,605,000.00
354	Хангамжийн материал	200,498,738.15	1,408,817,628.60
35410	Бичиг хэргийн материал	1,072,746.15	1,643,670.00
35420	Аж ахуйн материал	9,198,362.00	30,651,454.60
35470	Бусад хангамжийн материал	190,227,630.00	1,376,522,504.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,775,719,442.42</u>	<u>4,859,983,510.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,775,719,442.42	4,859,983,510.10
392	Биет хөрөнгө	4,770,747,442.54	4,845,247,510.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,702,803,510.83	4,702,803,510.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(611,364,456.30)	(799,476,596.70)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	336,998,743.69	614,157,289.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(116,934,772.48)	(154,656,935.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	168,683,110.00	236,729,002.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,665,442.82)	(73,289,060.19)
39214	Бусад үндсэн хөрөнгө	433,817,709.39	433,817,709.39
39215	Хуримтлагдсан элэгдэл	(87,590,959.77)	(114,837,408.93)
393	Биет бус хөрөнгө	4,971,999.88	14,735,999.84
39301	Програм хангамж	3,770,000.00	3,770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,770,000.00)	(3,770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,050,000.00	30,050,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(10,078,000.12)	(15,314,000.16)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>18,197,791,135.05</u>	<u>20,309,474,923.62</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,970,177.00</u>	<u>5,472,793.59</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,970,177.00	5,472,793.59
413	Өглөг	4,970,177.00	5,472,793.59

**НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ-ЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	467,666.59
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	34,950.00
4136	Бусад өглөг	4,970,177.00	4,970,177.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,970,177.00	4,970,177.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,192,820,958.05	20,304,002,130.03
51	Засгийн газрын хувь оролцоо	18,192,820,958.05	20,304,002,130.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	26,193,931.87	26,193,931.87
51101	Өмч: - төрийн	26,193,931.87	26,193,931.87
512	Хуримтлагдсан үр дүн	18,166,627,026.18	20,277,808,198.16
51210	Өмнөх үеийн үр дүн	18,166,627,026.18	18,166,627,026.18
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,111,181,171.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,197,791,135.05	20,309,474,923.62

2.2 Аудит хийсэн орлого, үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,211,997,300.00	4,889,881,179.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,961,053,104.04
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,961,053,104.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,211,997,300.00	1,928,828,075.27
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,471,375,000.00	1,083,640,080.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,471,375,000.00	1,083,640,080.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	740,622,300.00	845,187,995.27
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	740,622,300.00	845,187,995.27
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,586,417,561.79	2,778,700,007.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,586,417,561.79	2,778,700,007.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,452,538,544.98	1,959,294,559.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,051,465.54	524,498,887.09
210101	Үндсэн цалин	299,622,231.57	298,251,881.11
210102	Нэмэгдэл	52,101,572.47	84,132,405.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,262,120.00	128,452,000.00
210104	Урамшуулал	21,065,541.50	13,662,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,248,201.97	67,624,952.67
210201	Тэтгэврийн даатгал	40,965,961.61	45,824,952.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,754,050.07	5,909,361.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,643,063.06	2,579,772.02

**НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ-ЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

210204	Ажилгүйдлийн даатгал	1,377,025.06	2,579,772.02
210205	Эрүүл мэндийн даатгал	5,508,102.17	10,731,094.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,220,750.00	-
210304	Байрны түрээс	2,220,750.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	41,292,320.10	41,903,770.15
210401	Бичиг хэрэг	2,276,800.00	8,921,256.15
210402	Тээвэр, шатахуун	14,332,000.00	20,490,195.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,973,099.10	8,388,727.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	3,617,592.00
210408	Бараа материал акталсны зардал	20,710,421.00	486,000.00
2107	Томилолт, зочны зардал	156,414,616.05	10,653,720.00
210701	Гадаад албан томилолт	155,914,616.05	10,653,720.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,448,177.00	157,782,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	154,325,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,000.00	957,000.00
210807	Газрын төлбөр	4,970,177.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	2,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,773,863,014.32	1,156,831,229.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,509,520,194.00	880,890,860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	264,342,820.32	275,940,369.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,133,879,016.81	819,405,447.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	388,823,620.00	1,900,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	388,823,620.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,704,707,316.86	817,505,447.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,704,707,316.86	817,505,447.66
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,348,079.95	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,348,079.95	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,374,420,261.79)	2,111,181,171.98
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	518,069.64	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	518,069.64	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(518,069.64)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,374,938,331.43)	2,111,181,171.98

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,193,931.87	20,541,565,357.61	20,567,759,289.48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,193,931.87	20,541,565,357.61	20,567,759,289.48
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	(2,374,938,331.43)	(2,374,938,331.43)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,193,931.87	18,166,627,026.18	18,192,820,958.05
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	26,193,931.87	18,166,627,026.18	18,192,820,958.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,193,931.87	18,166,627,026.18	18,192,820,958.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	2,111,181,171.98	2,111,181,171.98
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,193,931.87	20,277,808,198.16	20,304,002,130.03

**НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ-ЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>5,445,980,643.47</u>	<u>2,746,333,522.93</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,695,159,723.47	817,505,447.66
120	Нийтлэг татварын бус орлого	1,695,159,723.47	817,505,447.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,695,159,723.47	817,505,447.66
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,695,159,723.47	817,505,447.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,750,820,920.00	1,928,828,075.27
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,471,375,000.00	1,083,640,080.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,471,375,000.00	1,083,640,080.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,279,445,920.00	845,187,995.27
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,279,445,920.00	845,187,995.27
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>5,445,980,643.47</u>	<u>2,558,470,630.93</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,445,980,643.47	2,558,470,630.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,162,101,626.66	1,724,720,563.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,051,465.54	527,599,043.25
210101	Үндсэн цалин	258,098,237.07	285,626,962.15
210102	Нэмэгдэл	66,092,108.47	91,403,348.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,640,120.00	135,214,882.86
210104	Урамшуулал	21,221,000.00	15,353,850.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,248,201.97	67,713,788.02
210201	Тэтгэврийн даатгал	35,528,773.76	46,194,898.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,179,855.71	5,392,487.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,243,038.22	2,628,513.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,936,816.76	2,628,513.28
210205	Эрүүл мэндийн даатгал	8,359,717.52	10,869,376.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,220,750.00	-
210304	Байрны түрээс	2,220,750.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	20,168,399.10	54,896,152.00
210401	Бичиг хэрэг	1,863,300.00	7,852,180.00
210402	Тээвэр, шатахуун	14,332,000.00	20,490,195.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,973,099.10	8,353,777.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	18,200,000.00
2107	Томилот, зочны зардал	156,414,616.05	10,653,720.00

**НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ-ЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

210701	Гадаад албан томилолт	155,914,616.05	10,653,720.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,478,000.00	159,202,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	155,745,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,000.00	957,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	2,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,509,520,194.00	904,655,860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,509,520,194.00	904,655,860.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,283,879,016.81	833,750,067.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,538,823,620.00	16,244,620.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,538,823,620.00	14,344,620.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,704,707,316.86	817,505,447.66
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,348,079.95	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,348,079.95	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>187,862,892.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	187,862,892.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	187,862,892.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	187,862,892.00
222001	Тоног төхөөрөмж	-	21,140,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	166,722,892.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(187,862,892.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусаавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	848,652,000.0	845,187,995.3	3,464,004.7	99.6%
УРСГАЛ ЗАРДАЛ	848,652,000.0	845,187,995.3	3,464,004.7	99.6%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	832,307,300.0	828,943,375.3	3,363,924.7	99.6%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	530,804,800.0	527,599,043.3	3,205,756.8	99.4%
Үндсэн цалин	290,511,100.0	285,626,962.2	4,884,137.9	98.3%
Нэмэгдэл	103,295,600.0	91,403,348.2	11,892,251.8	88.5%
Унаа хоолны хөнгөлөлт	136,998,100.0	135,214,882.9	1,783,217.1	98.7%
Урамшуулал	-	15,353,850.0	(15,353,850.0)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,866,400.0	67,713,788.0	152,612.0	99.8%
Тэтгэврийн даатгал	46,149,100.0	46,194,898.0	(45,798.0)	100.1%
Тэтгэмжийн даатгал	5,429,300.0	5,392,487.5	36,812.5	99.3%
ҮОМШӨ-ний даатгал	2,714,700.0	2,628,513.3	86,186.7	96.8%
Ажилгүйдлийн даатгал	2,714,700.0	2,628,513.3	86,186.7	96.8%
Эрүүл мэндийн даатгал	10,858,600.0	10,869,376.0	(10,776.0)	100.1%
Хангамж, бараа материалын зардал	30,456,100.0	30,456,044.0	56.0	100.0%
Бичиг хэрэг	2,013,000.0	1,612,072.0	400,928.0	80.1%
Тээвэр, шатахуун	19,268,500.0	20,490,195.0	(1,221,695.0)	106.3%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,174,600.0	8,353,777.0	820,823.0	91.1%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,180,000.0	3,180,000.0	-	100.0%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	680,000.0	680,000.0	-	100.0%
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,500,000.0	2,500,000.0	-	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	200,000,000.0	199,994,500.0	5,500.0	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	200,000,000.0	199,994,500.0	5,500.0	100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,344,700.0	16,244,620.0	100,080.0	99.4%
Бусад урсгал шилжүүлэг	16,344,700.0	16,244,620.0	100,080.0	99.4%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,344,700.0	14,344,620.0	80.0	100.0%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0	1,900,000.0	100,000.0	95.0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	848,652,000.0	845,187,995.3	3,464,004.7	99.6%

**НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ-ЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	848,652,000.0	27,682,547.6	820,969,452.4	3.3%
Орон нутгийн төсвөөс	848,652,000.0	27,682,547.6	820,969,452.4	3.3%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	817,505,447.7	(817,505,447.7)	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	817,505,447.7	(817,505,447.7)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0%
Төсвийн байгууллага	1	1	-	100.0%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17	-	100.0%
Удирдах ажилтан	1	1	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100.0%

2.6 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	972,444,580.00
УРСГАЛ ЗАРДАЛ	972,444,580.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	972,444,580.00
Хангамж, бараа материалын зардал	24,440,108.00
Бичиг хэрэг	6,240,108.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,200,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	61,667,392.00
Тавилга	61,667,392.00
Томилолт, зочны зардал	10,653,720.00
Гадаад албан томилолт	10,653,720.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	156,022,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,745,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	277,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	719,661,360.00
Бараа үйлчилгээний бусад зардал	719,661,360.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	111,195,500.00
Дотоод эх үүсвэрээр	111,195,500.00
Тоног төхөөрөмж	111,195,500.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,083,640,080.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,083,640,080.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,083,640,080.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 148,348.7 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалингийн урьдчилгааг урьдчилгааны дансаар дамжуулаагүй гүйлгээ хийсэн.	1	148,341.7			1	148,341.7	1	148,341.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 357,516.3 мянган төгрөгийн 11 зөрчил илэрснээс зөрчлийг таслан зогсоох 187,950.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 169,565.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Тооллогын комиссын бүрэлдэхүүн нярав, нягтлан бодогчийг оруулсан.	1	-					1	-				
Анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу гүйлгээ хийсэн.	1	28,860.0					1	28,860.0				
Шагнал бэлтгэх гэрээт ажилд төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, бараа материалын дансаар дамжуулаагүй, шууд зардлаар тайлагнасан.	1	19,800.0			1	19,800.0						

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

**НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ-ЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

3 хүн тутмын нэг нь байгаа нь ажлын чиг үүрэг давхардах, гүйцэтгэх шатны ажиллагсдын ажлын бүтээмж буурч, ачааллыг ихэсгэж байна.	1	-				1	-			
НТЗАБ-аас автомашин хэрэглэж шатахуун гаргахдаа хаашаа ямар ажлаас явсан ажлын тайлан байхгүй байна.	1	20,490.2				1	20,490.2			
2021 онд ашиглалтад орсон шинэ барилгын 2 давхарт дотор заслын ажилд зардал гаргаж, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан.	1	37,575.0				1	37,575.0			
Үйл ажиллагааны хүрээнд тоног төхөөрөмж шинээр авахдаа хөрөнгө хүлээлцсэн акт, ашиглалтын заавар, угсралт, туршилт хийсэн ажлын акт байхгүй, тоног төхөөрөмжийн нэр, маркийг бичиж орлогод аваагүй.	1	68,900.0				1	68,900.0			
Толгойтын барилга, СХД-ийн 8 хорооны барилга болон ЧД-т байрлалтай барилгуудын хувийн хэрэг хөтлөөгүй, газрыг данс бүртгэлд тусгаагүй.	1	-				1	-			
Ашиглаж байгаа хангамжийн материалыг данс бүртгэлээс хасахдаа ТШЗ-ийн тушаал шийдвэр гараагүй, устгалтын акт үйлдээгүй байна.	1	13,740.4				1	13,740.4			
Үндсэн хөрөнгийн үнэ, орлогод авсан хугацаа нь өөр өөр байхад ижил нэрээр ижил код өгсөн өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	59,860.7		1	59,860.7					
Асар түрээслэхдээ худалдан авах ажиллагааны хуулийн дагуу нээлттэй тендер зарлаагүй, 4 компанитай шууд гэрээ байгуулсан	1	108,290.0		1	108,290.0					
ДҮН	11	357,516.3		3	187,950.7	8	169,565.6			

**НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ-ЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн нийт 61,359.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	61,359.2			1	61,359.2		
ДҮН	1	61,359.2			1	61,359.2		